



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 4/6

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад ┐  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст шилжүүлсэн 62,567,000.00 (жаран хоёр сая таван зуун жаран долоон мянган) төгрөгийн балансын үнэ, 14,039,115.15 (арван дөрвөн сая гучин есөн мянга нэг зуун арван таван төгрөг арван таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс болон Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нар дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005982

22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 08 дугаар сарын 28 ны өдрийн  
№8 дугаар тогтоолыг хавсралт

ДОРНОД АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭСТ ШИЛЖҮҮЛСЭН, ДОРНОД АЙМГИЙН ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт балансын үнэ, /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Микрофоны пулт	12/25/2021	ш	1	1,320,000.00	1,320,000.00	329,773.85	990,226.15
2	Хурлын микрофон	12/25/2021	ш	11	352,000.00	3,872,000.00	967,333.95	2,904,666.05
3	Дэлгэц лед	12/25/2021	ш	4	455,000.00	1,820,000.00	454,687.80	1,365,312.20
4	Хурлын вэб камер, спикер мик	12/25/2021	ш	1	1,980,000.00	1,980,000.00	494,662.60	1,485,337.40
5	Хурлын лед дэлгэц 2*3,5м	12/25/2021	м2	7	4,400,000.00	30,800,000.00	7,694,729.25	23,105,270.75
6	Лед дэлгэцийн удирдлага	12/25/2021	ш	1	2,750,000.00	2,750,000.00	687,028.55	2,062,971.45
7	Суурин компьютер /хурал/	12/25/2021	ш	1	3,520,000.00	3,520,000.00	879,398.15	2,640,601.85
8	Чадалтай фульт	12/25/2021	ш	1	1,425,000.00	1,425,000.00	356,006.40	1,068,993.60
9	Яригч	12/25/2021	ш	2	735,000.00	1,470,000.00	367,248.40	1,102,751.60
10	Спикерийн хөл	12/25/2021	ш	2	110,000.00	220,000.00	54,961.70	165,038.30
11	Утасгүй микрофон/хос/	12/25/2021	ш	1	2,050,000.00	2,050,000.00	336,756.00	1,713,244.00
12	Хувцасны шкаб	12/23/2021	м2	31.5	360,000.00	11,340,000.00	1,416,528.50	9,923,471.50
<b>НИЙТ ДҮН</b>						62,567,000.00 (жаран хоёр сая таван зуун жаран долоон мянган)	14,039,115.15 (арван дөрвөн сая гучин есөн мянга нэг зуун арван таван төгрөг арван таван мөнгө)	48,527,884.85 (дөчин найман сая таван зуун хорин долоон мянга найман зуун наян дөрвөн төгрөг наян таван мөнгө)